



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ-3
ХӨГЖҮҮЛЭЛТ, САЙЖРУУЛАЛТЫН АЖИЛ**

Тендерийн нэр: *Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем
хөгжүүлэлт, сайжруулалтын ажил*

Тендерийн дугаар: **ЦДҮС-2019/ХА-28**

Огноо: 2019.06.27

2019-06-27

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем хөгжүүлэлт, сайжруулалтын ажил”** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх Ажлын даалгавар болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийг 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 11:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДҮС” ТӨХК-ний байр 3 дугаар давхар 311 тоотод 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 11:10 цагт тендерийг нээнэ.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар 309 тоот.

***Худалдан авах ажиллагаа, Ханган нийлүүлэлтийн хэлтэс.
Утас: 99248880. Факс:976-70043287***

Хоёр ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх
хугацаа**

**6. Алдааг
залруулах**

6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал
болгосон
үнэ,
түүнийг
үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал маягтын дагуу ирүүлэх; 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулж ирүүлнэ/ 3. Татварын цахим тодорхойлолт; 4. Шүүхийн тодорхойлолт; 5. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн эсэх талаар шүүхийн тодорхойлолт; 6. Тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байх; 7. Сүүлийн нэг жилийн буюу 2018 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; 8. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаархи мэдээлэл ирүүлнэ. /сүүлийн 2 жил / 9. Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн талаар /гэрээний хуулбар комиссын актны хуулбар хавсарган ирүүлэх/ 10. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарь гаргаж, төлөөлөх эрх бүхий этгээд баталгаажуулж ирүүлнэ. 11. Төсөв хийж ирүүлнэ. Төсвийг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэж эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна; 12. Магадлашгүй ажлын зардал, норм нормативийн сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлнэ; 13. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, ажил гүйцэтгэх үе шатны хуваарьт багтаан ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай баталгааг бичгээр ирүүлнэ; 14. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга; <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендер оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 07 дугаар сарын 22-ны</p> <p>Цаг: 11 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот-21013, Хан-Уул дуурэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3-н давхар, 309 тоот</p> <p>Огноо: 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр нээлт хийнэ.</p>

	Цаг: 11 цаг 10 минут
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ: “Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем хөгжүүлэлт, сайжруулалтын ажил” ЦДҮС-2019/ХА-28
Бусад:	Хөнгөлөлт урамшуулал үзүүлэх бол албан бичгээр ирүүлнэ.

Дөрөв. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ УДИРДЛАГА, МЭДЭЭЛЛИЙН
СИСТЕМ-3 – ИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

Гарчиг

1. Төслийн зорилго, хүрэх үр дүн.....
2. Хамрах хүрээ
3. Төслийн багийн ажил үүргийн хуваарь
- 3.1. Багийн ахлагч/Төслийн удирдагч
- 3.2. Системийн хөгжүүлэгч
4. Төслийн багт тавигдах шаардлага
- 4.1. Багийн ахлагч/Төслийн удирдагч.....
- 4.2. Систем хөгжүүлэгч
5. Төслийн удирдлага болон хяналт
6. Төлөвлөгөө.....
7. Тест болон туршилт.....
8. Системийг хүлээн авах, зөвшөөрөх
9. Гүйцэтгэл ба төлбөр.....
10. Програм хангамжийн шаардлага.....
- 10.1. Системийн зорилго.....
- 10.2. Ерөнхий шаардлага.....
- 10.3. Ажлын даалгавар
- 10.3.1. Гүйцэтгэгчийн ажлын даалгавар.....

1. Төслийн зорилго, хүрэх үр дүн

Цахилгаан дамжуулах сүлжээн дэх их хэмжээний мэдээллийн бүртгэл, өгөгдлийн зохион байгуулалт болон үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ЦДҮС ТӨХК нь “Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем-3” /ДСУМС-3/ -ийг боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.

Цахилгаан дамжуулах сүлжээний дотоод үйл ажиллагаа болон шуурхай ажиллагаа, шугам тоноглолын үзлэг, засварын үйл ажиллагааг цахимжуулж, тус үйл ажиллагаануудад дүн шинжилгээ хийх, тайлан бүртгэл хийх үйл ажиллагааг сайжруулах, төлөвлөх болон шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр инженер техникийн ажилчдыг хангах, шуурхай ажиллагааны мэдээллийг тогтмол хугацаанд удирдлагуудад хүргэх суурь систем байна.

2. Хамрах хүрээ

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн бүх салбарууд, дэд станцууд зэрэг тус компанийн сүлжээнд холбогдсон бүх газар хамрагдана.

3. Төслийн багийн ажил үүргийн хуваарь

Системийн хөгжүүлэлтийн багийн гишүүд дараах үүргийг гүйцэтгэнэ.

3.1 Багийн ахлагч/Төслийн удирдагч

Төслийн удирдагч нь төслийн удирдлага болон том хэмжээний мэдээллийн систем боловсруулах төлөвлөлт, хяналтыг хэрэгжүүлж байсан туршлагатай байна. Багийн ахлагч хөгжүүлэлтийн багийн үйл явцын болон бусад тайланг ЦДҮС ТӨХК-аас томилогдсон эрх бүхий ажилтанд ажлын явцын талаар тайлагнах үүрэгтэй ажиллана.

Ажлын үүрэг

- Шийдвэр асуудлууд, ажлын гүйцэтгэлийг тайлагнаж, шийдвэрлэх
- Хөгжүүлэлтийн багийн төлөвлөгөөг боловсруулах
- Багийн ажлын даалгавар, зорилго, зорилтыг нарийвчлан тодорхойлох
- Хөгжүүлэлтийн багийг удирдах
- Үйл ажиллагааны болон эрсдэлийн удирдлагыг төлөвлөх
- Уулзалтуудыг зохион байгуулах
- Явцын болон эцсийн тайлан бэлтгэх
- Багийн үйл ажиллагаа болон төслийн хүрээнд үүссэн асуудлыг хооронд нь уялдуулах
- Системийн туршилтын үйл явцыг удирдана.
- Хэрэглэгчийн сургалт зохион байгуулна.

Багийн удирдагч нь ЦДҮС ТӨХК-нд одоогийн байгаа мэдээллийн системд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр уг системийн шийдлийн төлөвлөлт, ажлын даалгаварт тусгагдсан програм хангамж, систем хөгжүүлэлтийн үе шатууд болон шаардлагад нийцэж байгааг хянаж ажиллана. Багийн ахлагч нь програмын хэл, үйлдлийн систем, компьютерийн техник хангамжийн мэдлэгтэй, ажлын туршлагатай байх шаардлагатай. Мөн хөгжүүлэлтийн шинжилгээ, дизайн, хэрэгжүүлэлтийн үе шатуудыг хариуцан ажиллана.

3.2 Системийн хөгжүүлэгч

Системийн хөгжүүлэгч нь системийн техникийн шаардлагын дагуу програмын эх кодыг бичих ажлыг хариуцан ажиллана. Мөн системийн өгөгдлийн сангийн загвар, системийг ирээдүйд өргөтгөхөд шаардлагатай програмчлалын кодын дэлгэрэнгүй тайлбар, өгөгдлийн санг өргөжүүлэх төлөвлөлт, системийн өгөгдлийн сангийн хурдыг тогтвортой байлгахад шаардлагатай зөвлөмжүүдийг боловсруулна.

Систем хөгжүүлэгч системийн нууцлал аюулгүй байдлыг өгөгдлийн сангийн түвшинд, програмчлалын түвшинд хэрхэн хангаж буй талаар дэлгэрэнгүй баримт бичгийг боловсруулж, уг нууцлалын шаардлагуудыг хэрхэн хангаж буйг баримтжуулна.

Ажлын үүрэг

- Системийн үндсэн архитектурыг боловсруулах
- Хэрэглэгчийн интерфейс дизайн боловсруулах
- Шаардлагын дагуу код бичих
- Шаардлагын дагуу системийн тайлангийн хэсгүүдийг хийх
- Системийн туршилт хийх

4. Төслийн багт тавигдах шаардлага

4.1 Багийн ахлагч/Төслийн удирдагч

Ерөнхий шаардлага

- Хувь хүний зохион байгуулалт сайтай. Багийн гишүүдийг урамшуулах болон тэдэнд ажлын шаардлагыг зөв тавьж чаддаг.
- Төлөвлөгөө гаргах, зохион байгуулах болон төслийн менежмент хийх чадвартай байх.
- Ярианы болон бичгийн чадвартай байх
- Багаар ажиллах чадвартай, туршлагатай байх
- Ажлын өндөр хариуцлагатай болон зарчимч байх

Тусгай мэдлэг чадвар

- Цахилгаан эрчим хүчний салбарт мэдээллийн систем боловсруулах чиглэлээр ажиллаж байсан эсхүл энэ салбарын талаар өндөр мэдлэгтэй
- Урт хугацааны болон том хэмжээний мэдээллийн технологийн төслийн хэрэгжүүлэлтийн менежментийн туршлагатай байх
- Төслийн талаарх баримтыг нэгтгэх болон тайланг ЦДҮС ТӨХК-д тавих чадвартай байх
- Төслийн хүрээнд шаардлагатай алхам, татгалзах болон зөвшөөрөх чадвартай байх

Шалгуур үзүүлэлт

- Багын ахлагч нь Монгол Улсын иргэн байх ба таваас доошгүй жил тухайн салбартаа ажилласан байх шаардлагатай байх
- Бичиг баримт хөтлөлтийн сайн чадвартай байх
- Төслийн менежментийн чадвартай, төслийн төлөвлөгөө гаргах, бичгийн програм дээр ажиллах чадвартай байх. Жишээ нь: MS Visio, MS Project, MS Excel, MS Word, MS PowerPoint
- Цахилгаан эрчим хүчний салбарт мэдээллийн систем боловсруулах чиглэлээр ажиллаж байсан эсхүл энэ салбарын талаар өндөр мэдлэгтэй байх.

4.2 Систем хөгжүүлэгч

Ерөнхий шаардлага

- Хувь хүний зохион байгуулалт сайтай. Багаар ажиллах чадвартай байх.
- Ажлын өндөр хариуцлагатай болон зарчимч байх

Тусгай мэдлэг чадвар

- Том хэмжээний системийг зохион бүтээсэн болон хэрэгжүүлж байсан туршлагатай байх
- Цахилгаан эрчим хүчний салбарт мэдээллийн систем боловсруулж, нэвтрүүлж байсан туршлагатай байх
- Төхөөрөмжүүдээс RS485, PLC холболтоор мэдээлэл солилцох програм хангамж боловсруулж байсан туршлагатай байх.
- Мобайл аппликэйшн боловсруулж байсан туршлагатай байх.
- Мэдээллийн системийн бүтцийг сайн мэддэг байх.
- Ерөнхий шаардлагуудыг олж чаддаг чадвартай байх.
- Бүх төрлийн програм хангамж болон техник хангамжийн мэдлэгтэй байх
- Бие даан системийг засварлах, хөгжүүлэх болон томоохон хэмжээний системийг суурилуулах чадвартай байх.

Шалгуур үзүүлэлт

- Монгол Улсын иргэн байх ба таваас доошгүй төсөл дээр ажилласан байх шаардлагатай

- Их дээд сургуулийн компьютерийн шинжлэх ухааны чиглэлээр эсхүл мэдээллийн системийн чиглэлээр төгссөн байх. Мэргэжлээрээ таваас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх.
- Програмчлалын хэлний мэдлэгтэй байх. Жишээ нь:
 - Вэб програм болон вэб сервис:
 - Java програмчлалын хэл (Standart & Enterprise Edition)
 - Java EE дэмждэг вэб сервер (WildFly, JBoss, Tomcat, GlassFish, Liferay)
 - Enterprise services bus (ESB) Apache ServiceMix
 - SOAP, REST вэб сервис (XML, JSON)
 - WebSocket
 - Oracle, MSSQL, MySQL өгөгдлийн сан
 - HTML 5, CSS 3, Javascript
 - Unix, Linux үйлдлийн систем
 - Desktop програм:
 - C# програмчлалын хэл
 - .NET framework
 - Mobile application програм:
 - Android үйлдлийн систем

5. Төслийн удирдлага болон хяналт

Програм хангамж хөгжүүлэлтийн төлөвлөлт болон зохион байгуулалт нь програм хангамж хөгжүүлэх багийн маш чухал үе шат юм. Багийн зохион байгуулж буй ажил болон системийн загвар гүйцэтгэл зэргийг ЦДҮС ТӨХК-ийн томилогдсон эрх бүхий ажилтан хянана.

6. Төлөвлөгөө

Хэрэгжүүлэх үе шат нь төслийг хэрэгжүүлж дуусах өдөртэй ижил хугацаанд дуусах шаардлагатай бөгөөд хэрэв хамт дуусаагүй тохиолдолд төслийн амжилттай дууссаныг дүгнэх боломжгүй юм. Төсөл хэрэгжиж дуусах хугацаа 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байх ба уг хугацаанаас өмнө төсөл бүрэн хэрэгжиж дууссан байх шаардлагатай.

№	Ажлын нэр	Голчлох үр дүн	Хугацаа
1	Цар хүрээ, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах.	Цар хүрээг тодорхойлох, ажил болон түүний нарийвчилсан задаргаа. Ажил үүргийг хуваарилан шаардлагатай хугацааг тооцоолох. Gantt chart	14 хоног
2	Дизайн шинжилгээ хийх	Мэдээллийн сангийн бүтцийг тодорхойлох, үйл ажиллагааны урсгал, ажил хоорондын хамаарлыг тодорхойлох	14 хоног
3	Кодчилал	Үндсэн ажиллах зарчим болон хэрэглэгчийн интерфэйсийг бий болгох	60 хоног
4	Нэвтрүүлэлт	Гарсан алдаа дутагдлыг залруулах	14 хоног

5	Тестлэх, турших		14 хоног
6	Бусад системээс өгөгдөл хөрвүүлэх	Техникийн нэгдсэн мэдээллийн сан, Тоолуурын нэгдсэн мэдээллийн систем програмаас мэдээлэл хөрвүүлэх	14 хоног
7	Баталгаажуулах	Захиалагчид хүлээн зөвшөөрүүлэх, бичиг баримт бэлдэх	7 хоног

7. Тест болон туршилт

Тестлэх болон турших үе шат нь ЦДҮС ТӨХК-аас томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудын удирдлаган дор явагдах бөгөөд ажиллаж байгаа багт тестлэх болон туршилт хийх талаар нарийвчилсан даалгавар өгнө. Туршилт нь захиалагчид системийн үйл ажиллагаа болон чанарыг баталгаажуулан харуулна.

Дараах үүргийг гүйцэтгэнэ.

- Үйл ажиллагааны процессийн үе шат болгонд туршилтыг бэлдэх шаардлагатай.
- Хөгжүүлэлтийн үе шатанд систем гүйцэд шаардлага хангахаар бүтээгдсэн эсэхийг тогтоох
- Систем захиалагчийн хүссэн хэмжээнд хүрч ажиллаж буй эсэхийг шалгах
- Системийг цаашид тухайн байдлаар хөгжүүлж болох эсэх
- Захиалагчийн сэтгэлд нийцэж байгаа эсэх
- Чадвар болон чадамжийг дүгнэх
- Шалгалтын тайланд бэлдэх

8. Системийг хүлээн авах, зөвшөөрөх

ЦДҮС ТӨХК нь хөгжүүлэлтийн багийн нийлүүлсэн систем техникийн шаардлагын дагуу туршигчдийн тайлантай нийцсэн эсэхийг тодруулах болон зөвшөөрөх эрх бүхий багийг томилж ажил гүйцэтгэх актаар хүлээн авна.

9. Гүйцэтгэл ба төлбөр

ЦДҮС ТӨХК нь төслийн явцын болон эцсийн тайланг биет болон цахим хувиар хүлээн авч баталгаажуулж, зөвшөөрсний үндсэн дээр төлбөр хийгдэнэ.

Нийлүүлэлт нь доорхи шаардлагуудыг хангасны үндсэн дээр дүгнэгдэнэ. Үүнд:

- Хугацаандаа бүх шалгуур хангасан нийлүүлэлт хийгдсэн болох
- Ажлын үр дүн нь чанарын шаардлага хангасан, баталгаажсан байх
- Оролцогч талуудтай цаг хугацаанд харилцан ойлголцсон байх

№	Ажил гүйцэтгэл	Урьдчилан төлөвлөсөн хугацаа	Гэрээний сануулга	Төлбөр (Гэрээний дүн хувиар)
1	Цар хүрээ, нарийвчилсан	Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа	Төлөвлөгөөг 2 тал баталгаажуулсан байна.	30%

	төлөвлөгөө боловсруулах	хуанлийн 14 хоногийн дотор		
2	Дизайн шинжилгээ хийх	Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа 14 хоногийн дотор	Мэдээллийн урсгал, Системийн загвар, Модулиудын хэрэглэгчийн интерфэйсийн зохиомж, тайлангийн хэсгүүдийг танилцуулж, баталгаажуулах	0%
3	Кодчилал	Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа 2 сарын дотор	Ажлын гүйцэтгэлийн явцын тайлан.	0%
4	Тестлэх, турших	Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа 3 сарын дотор	Туршилтын тайлан болон илэрсэн алдаа дутагдлыг залруулсан байдал болон түүнийг залруулах арга, ирээдүйд тохиолдож болох боломжтой эрсдэлийг тодорхойлж тайлангаар танилцуулна.	0%
5	Эцсийн тайлан	Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа 3 сарын дотор	Сургалт хийгдсэн, систем бүрэн туршигдсан, нэвтрүүлэхэд бэлэн болсон, дагалдах баримт бичгүүд цаасан хэлбэрээр баталгаажсан. Ажил гүйцэтгэлийн акт үйлдсэн байна.	70%
-	БҮГД	3 сар		100%

10. Програм хангамжийн шаардлага

10.1 Системийн зорилго

Цахилгаан дамжуулах сүлжээн дэх их хэмжээний мэдээллийн бүртгэл, өгөгдлийн зохион байгуулалт болон үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ЦДҮС ТӨХК нь “Дамжуулах сүлжээний удирдлага, мэдээллийн систем-3”-ийг боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.

Цахилгаан дамжуулах сүлжээний дотоод үйл ажиллагаа болон шуурхай ажиллагаа, шугам тоноглолын үзлэг, засварын үйл ажиллагааг цахимжуулж, тус үйл ажиллагаануудад дүн шинжилгээ хийх, тайлан бүртгэл хийх үйл ажиллагааг сайжруулах, төлөвлөх болон шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр инженер техникийн ажилчдыг хангах, шуурхай ажиллагааны мэдээллийг тогтмол хугацаанд удирдлагуудад хүргэх суурь систем байна.

10.2 Ерөнхий шаардлага

Тус систем нь веб програмчлалын хэл дээр суурилсан цахим бүртгэлийн систем байна. Дэд системүүд нь веб болон мобайл аппликэйшн дээр суурилсан байна. Тус системийн мэдээллийн бааз нь MSSQL байна. ЦДҮС ТӨХК –ийн шуурхай ажиллагааны мэдээллийн бүртгэлийг хийх, шуурхай ажиллагааны удирдлага зохион байгуулалт хийхэд ашиглана. Тус системийг ЦДҮС ТӨХК-ийн үйл ажиллагаандаа ашиглаж буй бусад мэдээллийн системтэй (Тоолуурын нэгдсэн мэдээллийн сан, Техникийн нэгдсэн мэдээллийн сан) уялдаж ажиллах боломжтойгоор загварчилсан байна.

Хэрэглэгчийн шаардлага:

- Монгол хэл дээр, UNICODE ашиглана.
- Мэдээллийг нэг оруулж, олон дахин ашигладаг байх.
- Анхан шатны бүртгэлүүдийг баталсан маягтын дагуу бүртгэл хөтөлдөг байх
- Бүх бүртгэлийн түүхчилсэн сан хөтөлдөг байх
- Анхан шатны бүртгэлүүдийг компанийн бусад алба, хэлтэс, салбар дотроо мэдээллийн сантай холбож мэдээлэл солилцох боломжтой байхаар шийдсэн байх.
- Бүх бүртгэлээс бүх талбараар төрөл бүрийн хайлт хийж, үр дүнг гаргах хайлтын системтэй байх
- Хэрэглэгчийн эрхийг цэс, үйлдэл бүрээр зохицуулдаг тусдаа дэд системтэй байх
- Тайлангийн иж бүрэн дэд системтэй байх. (Батлагдсан маягтын дагуу)
- Гарын авлагатай байх

10.3 Ажлын даалгавар

10.3.1 Гүйцэтгэгчийн ажлын даалгавар

Гүйцэтгэгч нь уг төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- “Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем-3 –ийн мэдээллийн сангийн бүтцийг боловсруулах
- Сервер, програм хангамжийн суурилуулалт тохиргоог хийх
- Дамжуулах сүлжээний удирдлага, мэдээллийн систем-3 /ДСУМС-3/ -ийг хийж үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Техникийн мэдээллийн нэгдсэн сан програмыг ДСУМС-3-тай холбож интеграци хийх
- Эдийн засаг төлөвлөлтийн програмыг ДСУМС-3 -тай холбож интеграци хийх
- Компанийн тайлант жилүүдийн Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг Эдийн засгийн програм болон ДСУМС-3 програмаас харах боломжтой болгох.
- Санхүүгийн Diamond програмыг ДСУМС-3 –тай холбож интеграци хийх
- Санхүүгийн программын үндсэн хөрөнгийн өөрчлөлтийн хэсгийг ДСУМС-3-ын тоноглолын мэдээллийн хэсэгтэй холбох
- Төсвийн програмыг ДСУМС-3 -тай холбож интеграци хийх
- ДҮТ ХХК-ийн Disnews програмыг ДСУМС-3-тай холбож интеграци хийх
- Их засвар, ТЗБАХ, Урсгал засварын модулийг эдийн засгийн төлөвлөлтийн програмтай холбох
- ДСУМС-2 програмын веб интерфэйсыг бүрэн шинэчлэх
- ДСУМС-2 програмын өмнөх дизайныг бүрэн шинэчлэх
- ДСУМС-2 програмын мобайл програмыг бүрэн шинэчлэх
- ДСУМС-2 дээр байгаа бүх модулийг шинэчлэх
- Автомашинуудад зайн хяналтын GPS төхөөрөмж суурилуулж ДСУМС програмаар машины явсан маршрутыг хянах боломжтой болгох
- Програмын ачааллах хугацааг багасгаж, хурдыг нэмэгдүүлэх
- ДСУМС програмын гар утасны аппликейшнээр програмд нэвтрээд 1 цаг үйлдэл хийхгүй бол автоматаар програмаас гарч байгааг 8 цаг болгож сунгах
- ДСУМС-2 мобайл програмд ашиглаж буй гар утаснуудын 3G сүлжээний холболтыг сайжруулах
- Бүх модулын хайлтын хэсгийг шинэчлэх
- ДСУМС-2 –ийн веб програм болон мобайл аппликэйшны модулуудад нэмэлт хөгжүүлэлт хийж сайжруулах

Реле хамгаалалтын талаар програмд хийгдэх ажлууд /тоолуур, хэмжүүр/ :

- ДҮТ ХХК-ийн тоолуурын системд холбогдох боломжгүй байгаа DLMS/COSEM, IEC62056 протокол дэмжих боломжтой тоолууруудаас мэдээлэл татах, боловсруулалт хийх програм
- ДСУМС-3 програмын тоолуурын мэдээллийн санг тарифт тоолуурын сан болгон өөрчилж, мэдээллийн баазын бүтцийг өөрчлөх
- Дамжуулсан цахилгаан кВт.цаг тооцоолж, оролт гаралтын тоолууруудаар энергийн балансын модуль хийх
- ЦДҮС ТӨХК-ийн 220/110/35 кв-ын дэд станцуудад ашиглагдаж байгаа бүх тоолуураас мэдээлэл авах
- Тоолуурын заалт болон ачааллын мэдээг автоматаар /SEL, Альфа центр / програмаас татдаг болгох
- Хамгаалах хэрэгслийн туршилт модулийг шинэчлэх
- Тоноглолын туршилт хэсгийн мэдээллийг Excel хэлбэрээр татаж авах боломжтой болгох
- Тоноглолын туршилт модулийг шинэчлэх
- Акт протоколуудыг цахим хэлбэрээр оруулах модулийг шинэчлэх
- Дэд станцуудын хоёрдогч хэлхээний схемүүдийг оруулах
- Дэд станцуудын тавилын карт оруулах
- Дэд станцуудын тоолуурын заалтаар бланс хийдэг болгох
- API, Вэб сервис үүсгэж, тоолуурын нэгдсэн системээс мэдээлэл татаж, боловсруулалт хийх

Шуурхай ажиллагааны талаар програмд хийгдэх ажлууд :

- Дэд станцуудын анхдагч хэлхээний схемийг оруулах
- Тоноглолын шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийх
- Сэрэмжлүүлэх мэдээлэл даалгаврын модуль хийх
- Албан даалгавар зөвлөмжийн модуль хийх
- Ажлын хувиарлалт, үүрэг даалгаврын модулийг шинэчлэх
- Технологийн зөрчлийн модулийг шинэчлэх
- ХАБЭА-ны сарын ажлын тайлан, тоо мэдээг гаргах
- Ажлын байрны үзлэгийн модуль хийх
- Зааварчилгааны модулийг шинэчлэх
- Ачааллын мэдээ оруулах модулийг шинэчлэх
- Өдөр тутмын зааварчилгаанд бүх засварын монтерүүдын нэрийг харагддаг болгох
- Шуурхай ажиллагааны мэдээллийг засварлах үед зөвхөн засвар хийсэн мэдээллийг харуулдаг болгох
- Дотоод хэрэгцээний коэффициент оруулдаг болгох
- Зааварчилгаа авсан ажилтны гарын үсгийг таньдаг болгох
- Програмын шинэчлэл хийгдэх үед системийн бүх хэрэглэгчид хийгдсэн өөрчлөлтийн талаарх notification ирүүлдэг болгох
- Гэрийн жижүүртэй дэд станцуудад ээлж хүлээлцэх модулийг өөрчлөх
- Наряд, сэлгэн залгалтын модулийг шинэчлэх
- Evolis Sig 100 Signature Pad Цахим гарын үсэг зурах төхөөрөмжийг ДСУМС-3 програмтай холбох
- ДСУМС-3 програмын ИЗ-ын ажилд барилга, автомашины бүртгэлийг оруулах
- Сэлгэн залгалтын програмыг шинэчлэх
- Дэд станцын тоолуураас актив, реактив заалт, чадал, гүйдэл, хүчдэлийн мэдээллийг 1 цаг тутам авч түүхчилсэн мэдээллийн бааз үүсгэх, өгөгдөл автоматаар цуглуулах
- Ээлжийн хуваарийн модулийг шинэчлэх
- Ажилтны байршлын мэдээллийг GPS-ээс хугацааны хоцрогдолгүй харуулах
- Ажилтны байршил бүртгэх ажилтнуудын лавлах санг хийх
- Ачааллын мэдээллийн урсгалын + - аар бүртгэдэг болгох
- Шатахууны тооцооны модулийг шинэчлэх

- Их бага ачааллын мэдээг шинэчлэх
- Мобайл програмыг идэвхтэй болон идэвхгүй байгааг ялгаж харуулдаг болгох
- GPS ийн байрлалыг гар утсан дээр offline аар хадгалдаг боломжтой болгох
- Гэмтлийн журналын тухай бүр бүртгэгдээд устгасан гэмтлүүдийг харагддаг болгох
- ИХБ-ын тоноглолын халалт хэмжилтийг шинээр оруулдаг болгох
- Дэд станцуудын инженер, монтер нарыг станц тус бүрээр нэг дор дараалж харуулдаг болгох
- Захиалга дээр засвар хийдэг болгох, захиалга сунгагдсан үед хугацаа өөрчлөх боломжтой болгох
- Захиалга оруулахад ЦДАШ болон гарсан шугамуудын мэдээллийг харуулдаг болгох
- Захиалгын журнал цэсэнд ИЗА, УЗА, ТЗБАХ-ийн төлөвлөгөөт ажлуудын захиалга бүртгэх модулийг шинэчлэх, өмнөх оны ажил хийгдэх тохиолдолд захиалгыг бүртгэх боломжтой болгох
- Тасралт, таслалт цэсний жагсаалтыг ТМНС-ийн мэдээлэлтэй интеграци хийж тулгах модуль хийх
- ЦДАШ-ийн лавлах сангийн модуль хийх
- Автомашин, механизмын санг салбар тус бүрээр тусад нь үүсгэх
- Диспетчерийн алба цэсэнд мэдээлэл технологи, холбооны ээлжит үзлэгийн график оруулах
- Мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцсэн цахим гарын үсгийн төхөөрөмжийг програмд холбох /Зааварчилгаа, наряд, сэлгэн залгалтад ашиглах/
- Дэд станцуудыг хүчин чадал, байршлаар нь ангилж категоричласны дагуу ээлжийн графикийн хувилбарыг хийх
- Техникийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн тасралт, таслалт, гэмтлийн тоог ДСУМС программд татахдаа хяналт баталгаажуулалтыг тусгах
- Тоноглолын нэршил зөрсөн хэсгүүдийг засах
- Нарядын техникийн арга хэмжээний дарааллыг хүснэгт хэлбэрээр оруулах, мөр нэмэх, хасах, засвар хийх боломжтой болгох
- Нарядын бригадын бүрэлдэхүүнд зөвхөн нэг цонхноос ажилтнууд сонгодгийг засах
- Ажлын гүйцэтгэл оруулсан ажил материалын нябо-д хийгдэж байгаагаар харагдаж байгааг ажлын гүйцэтгэл ороход санхүүд хийгдэж дууссан болгох.
- Гэмтлийн журналын гэмтлийг ангилан ЗА, АА, РХАХТА, гаднын байгууллагын гэмтэл, шугамын гэмтэл гэж ялгаж оруулдаг болгох
- 03 болон 19 цагийн ачааллын мэдээг диспетчерт харагддаг болгох
- Олон шугамын ачааллын мэдээг оруулах функцийг сайжруулах
- Ачааллын мэдээ болон тоолуурын заалтын мэдээлэл оруулах функцийг сайжруулах
- Бусад дэд станцад ямар горим схемээр, ямар ажилтнууд гарч байгааг ээлжинд гарч байгаа хүмүүст харагддаг болгох
- Үзлэгийг гар утаснаас /дуу, дүрс/ оруулдагтай адил компьютероос оруулах боломжтой болгох

- Үзлэгийг гар утаснаас хийхэд үзлэгийн журнал дээр давхар оруулдаг болгох
- ЦДАШ ээлжит үзлэгийн график оруулах, үзлэгийн дүн гүйцэтгэл гаргадаг болгох
- Шуурхай ажиллагааны журналыг 24 цагийн дотор засах боломжтой байх
- Ээлжийн графикт өөр алба руу шилжсэн, ажлаас гарсан гэх мэт төлвүүдийг нэмэх боломжтой болгох
- Шуурхай ажиллагааны журналын функцийг сайжруулах
- Ашиглалтын албаны цэсэнд нэмэлтээр тусгай дугаараас мессеж явуулах функц нэмж өгөх

Мэдээ тайлан, судалгааны талаар програмд хийгдэх ажлууд :

- Их, урсгал засвар, техник зохион байгуулалтын тайлангуудын хэсэгт хяналт, баталгаажуулалтыг оруулах
- Зөрчлийн талаарх мэдээллүүдийг нэг хүснэгтэд багтаан харуулах

- Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, ажилтнуудын хувцсыг картжуулах, бүртгэл болон тайлангийн модуль хийх.
- Тоолуурын нэгдсэн судалгааны тайлан. Баталгаажуулалт, хүчдэлийн түвшин, марк, улс, салбар, дэд станц г.м.
- Хэмжүүрийн трансформаторын нэгдсэн судалгааны бүртгэл болон тайлан судалгааны модуль хийх
- Мониторинг модулийг шинээр хийх. ИЗА, ТЗБАХ, УЗА, тасралт, тасралт гэх мэт програмд бүртгэгдсэн бүх мэдээлэлд мониторинг хийх
- ИЗА, ТЗБАХ, УЗА мэдээг алба бүрээр, ажил бүрээр задаргаагаар гаргах, нэмэлт тайлангууд хийх
- ИЗА, ТЗБАХ, УЗА-ын материалын захиалгын хуудас, шаардах хуудсыг гаргах
- ИЗА, ТЗБАХ, УЗА төсвийг оруулах, ажлын гүйцэтгэлийн актыг хэвлэж гаргах, нэмэлт тайлангууд хийх
- Автомашины захиалгын журналыг үндэслэн жолоочийн тооцооны хуудсыг гаргах
- Үндсэн хөрөнгийг дотоодод шилжүүлэх, дагалдах хуудас, үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх маягтын хуудас гаргах
- Шаардлагатай мэдээ тайлангуудыг тодорхой загварын дагуу боловсруулах.
- Ашиглалтын төвшний судалгааг гаргадаг болгох
- Ажлын гүйцэтгэл модуль, гүйцэтгэлийн товчоо тайланг шинэчлэх
- Хэмжүүр , тоолуур, гүйдэл хүчдэлийн трансформаторын судалгааг протоколуудын хамт оруулдаг болгох, дууссан хугацааг мэдээлдэг болгох
- Салбаруудын хөтлөгдөж буй мэдээ, тайланг нэг стандартад оруулах / ээлжийн график, шуурхайн мэдээ г.м /
- Транзит шугамын урсгал тоолуурын тайланд харагдахгүй байгааг харуулдаг болгох

“Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем-3” нь ДСУМС-2-ийн вэб програмд ашиглагдаж байгаа дараах модулуудад нэмэлт хөгжүүлэлт хийх болон бусад модулын хөгжүүлэлтээс бүрдэнэ.

Үүнд:

- Дүрэм журам
 - Албан даалгавар
 - Тушаал
 - Хууль, дүрэм
- Телефонограм
 - Танилцаагүй
 - Танилцсан
- Сэрэмжлүүлэх мэдээ
- Диспетчерийн алба
 - Авто зогсоол, орц, гарц
 - Ажлын гүйцэтгэл
 - Ажлын гүйцэтгэлийн тайлан
 - Ажлын хувиарлалт
 - Диспетчерийн
 - Гадны байгууллага
 - Гадны байгууллага /Шинэ/
 - Бусад албад
 - Гадуур ажлын жагсаалт
 - Ачааллын мэдээ хяналт
 - Гадны байгууллага бүртгэх
 - Гэмтлийн журнал
 - Дэд станцын тоноглол
 - Дэд станцын тасралтын журнал
 - Дэд станцын таслалтын журнал
 - Зааварчилгааны журнал
 - Өдөр тутмын зааварчилгаа
 - Диспетчерийн зааварчилгаа
 - Зарчмын схем
 - Салбар
 - Дэд станц
 - Фидерийн нэршлийн өөрчлөлт
 - Захиалгын журнал

- Зуны ачааллын хэмжилт
- Их бага ачаалал хяналт /19,03/
- Их бага ачааллын бүртгэл
- Мессеж
 - Бүртгэл
 - Мессеж илгээх
 - Мессеж илгээсэн түүх
- Мэдээ хянах
- Өвлийн ачааллын хэмжилт
- Наряд шийдвэрийн журнал
- Нарядын тайлан
- Сондгой цагийн мэдээ хяналт
- Сэлгэн залгалт
 - ДҮТ болон компанийн
 - Салбарын сэлгэн залгалт
- Телефонограмм
- ТМНС-ийн гэмтэл
- ТМНС-ийн тасралт
- ТМНС-ийн таслалт
- Үзлэг
- Халалтын хэмжилт
- Шуурхайн мэдээ
- Шуурхай ажиллагааны журнал
- Ээлжийн график
- Ашиглалтын алба
 - Авто зогсоол, орц, гарц
 - Ажлын гүйцэтгэл
 - Ажлын гүйцэтгэлийн тайлан
 - Ажлын хувиарлалт
 - Ачааллын мэдээ
 - Ачааллын график
 - Гарын авлага
 - Гадуур ажлын цаг бүртгэх
 - График
 - Гэмтлийн журнал
 - ДҮТ тоолуурын заалт
 - Зааварчилгааны журнал
 - Өдөр тутмын зааварчилгаа
 - Зарчмын схем
 - Салбар
 - Дэд станц
 - Фидерийн нэршил өөрчлөлт
 - Их бага ачаалал /19, 03/
 - QR код үүсгэх
 - Наряд шийдвэрийн журнал
 - Нарядын тайлан
 - Реле хамгаалалтын тавил
 - Сэлгэн залгалт
 - Захиалгын журнал

- ДҮТ болон компанийн
 - Салбарын сэлгэн залгалт
- Тасралтын мэдээлэл
- Таслалтын мэдээлэл
- ТМНС-ийн гэмтэл
- Тоолуурын заалт оруулах
- Тоолуурын бүртгэл
- Тоолуурын заалтын мэдээлэл
- Үзлэг
- Үзлэгийн хуваарь
- Үүрэг даалгавар
- Халалтын хэмжилт
- Шуурхайн мэдээ
- Шуурхай ажиллагааны журнал
- Ээлж хүлээлцэх
- Ээлжийн график
- Засварын алба
 - Авто зогсоол, орц, гарц
 - Ажлын гүйцэтгэл
 - Ажлын гүйцэтгэлийн тайлан
 - Ажлын хуваарилалт
 - Гэмтлийн журнал
 - Наряд шийдвэрийн журнал
 - Нарядын тайлан
 - Үзлэг
 - Үзлэгийн хуваарь
 - ТМНС-ийн гэмтэл
 - Шуурхайн мэдээ
- РХТА
 - Авто зогсоол, орц, гарц
 - Ажлын гүйцэтгэл
 - Ажлын гүйцэтгэлийн тайлан
 - Ажлын хуваарилалт
 - Гэмтлийн журнал
 - QR код үүсгэх
 - Наряд шийдвэрийн журнал
 - Нарядын тайлан
 - Үзлэг
 - Трансформаторын хэмжилт
 - Тайлан
 - ТМНС-ийн гэмтэл
 - Тоноглолын туршилт
 - Тоолуурын бүртгэл
 - Хамгаалах хэрэгслийн бүртгэл
 - Хамгаалах хэрэгслийн туршилт
 - Шуурхайн мэдээ
- ХАБЭАИ
 - Авто зогсоол, орц, гарц
 - Ажлын хуваарилалт

- Бусад мэдээлэл
- Зааварчилгааны журнал
 - Диспетчерийн зааварчилгаа
 - Ээлжийн инженер, монтёр
- Технологийн зөрчил
- ХАБ-н 3-р шатны үзлэг
- ХХ-ын сарын мэдээ
- Шугамын тасралтын дүгнэлтүүд
- Шуурхайн мэдээ
- ЗУ Алба
 - Авто машины захиалгын журнал
 - Авто зогсоол, орц, гарц
 - Ажлын хуваарилалт
 - Ажлын гүйцэтгэл
 - Илүү цаг
 - Илүү цагийн тайлан
 - Ээлжийн график
 - Шуурхайн мэдээ
- Тээвэр аж ахуйн алба
 - Авто машины захиалгын журнал
 - Авто зогсоол, орц, гарц
 - Ажлын хуваарилалт
 - Ажлын гүйцэтгэл
 - Илүү цаг
 - Илүү цагийн тайлан
 - Ээлжийн график
 - Шуурхайн мэдээ
- Санхүүгийн алба
 - Авто машины захиалгын журнал
 - Авто машины захиалга
 - Ажлын хуваарилалт
 - Ажлын гүйцэтгэл
 - Илүү цаг
 - Илүү цагийн тайлан
 - Ээлжийн график
 - Материал бүртгэл
 - Их засвар
 - Урсгал засвар
 - ТЗБАХ
 - Хөрөнгө оруулалт
 - Шуурхайн мэдээ
- Мониторинг
- Тайлан
- Гарын авлага
- Ажилтны байршил
- Тохиргоо
 - Ажилтны байршил тохиргоо
 - Арк
 - Албан тушаал

- Ажилтны жагсаалт
- Авто зогсоолын мэдээлэл
- Амралтын өдрүүд
- Гадны байгууллага
- Хэрэглэгчийн жагсаалт
- Хэлтэс, албадууд
- ЦДАШ-уудын ачаалал /ГХ/
- Тоолуурын мэдээлэл /ГХ/
- Зарлал мэдээлэл
- Их бага ачааллын бүртгэл
- Фидерийн эрэмбэ
- Энергийн баланс
 - Тайлан
 - Түгээхийн бүртгэл
 - Түгээхийн фидер
 - Түгээхийн станц
- График
- Лавлах сангууд
 - Өдөр тутмын зааварчилгаа
- Ажлын гүйцэтгэл
 - Төлөвлөгөөт ажил
 - Төлөвлөгөөт бус ажил
- Сэлгэн залгалтын лавлах
 - Горим бүртгэл
 - СЗҮ програм
- Диспетчерийн үндэсний төв
 - Тоолуурын заалт
 - Заалт авсан түүх
- Авто машины лавлах
 - Станцын зай бүртгэл
 - Авто машин бүртгэл
- Тайлан
 - Энергийн балансын мэдээ /дэд станц, хүчдэлийн түвшингээр/
 - Энергийн балансын мэдээ дэлгэрэнгүй
 - Ачааллын мэдээ
 - Ачааллын мэдээ /19 цаг/
 - Ачааллын мэдээ /03 цаг/
 - Шуурхай ажиллагааны журнал
 - Тасралтын журнал
 - Таслалтын журнал
 - Зааварчилгааны журнал /Өдөр тутмын зааварчилгаа/
 - Зааварчилгааны журнал /Тухайлсан зааварчилгаа/
 - Зааварчилгааны журнал /Ээлжит бус зааварчилгаа/
 - Зааварчилгааны журнал /Давтан зааварчилгаа/
 - Гэмтлийн журнал
 - Шийдвэрийн захиалгын журнал
 - Салбарын захиалгын журнал
 - Компанийн захиалгын журнал
 - ДҮТ-ийн захиалгын журнал

- Үүрэг даалгаврын журнал
- 110/35 кВ дэд станцуудаас гарсан зарим ЦДАШ-уудын ачаалал /Гэр хороолол/
- Тоолуурын заалт 110/35 кВ дэд станцуудаас гарсан зарим ЦДАШ-уудын ачаалал /Гэр хороолол/
- Тоолуурын заалтын мэдээлэл
- Халалтын хэмжилт
- Телефонограммын дэлгэрэнгүй журнал
- Их бага ачааллын мэдээ
- Сондгой цагийн мэдээ

“Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем-3” нь ДСУМС-2-ийн мобайл аппликейшнд ашиглагдаж байгаа дараах модулуудад нэмэлт хөгжүүлэлт хийх болон бусад модулын хөгжүүлэлтээс бүрдэнэ.

Үүнд:

- Үүрэг даалгавар
- Гэмтэл илрүүлэх
- Үзлэг хийх
- Наряд
- Ачааллын мэдээ
- Их бага ачааллын мэдээ
- Тоолуурын заалт
- Зааварчилгаа

10.3.2 Дамжуулах сүлжээний удирдлага, мэдээллийн систем-3 -ийн програм хангамж

Тус системийг ЦДҮС ТӨХК-ийн дараах салбарууд болон инженер техникийн ажилчид ашиглана. Үүнд:

Байгууллагын бүтэц

Салбар: 5

Ажилтны тоо: 1176

- Төв удирдлага
- Улаанбаатар салбар
- Төвийн бүсийн салбар
- Хангайн бүсийн салбар
- Зүүн-Өмнөд бүсийн салбар
- Говийн бүсийн салбар

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| | Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

9. Зөрчил, гологдол арилгах

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
- Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
- Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэл эс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем хөгжүүлэлт, сайжруулалтын ажил”

ЦДҮС-2019/ХА-28

ГЕН 2.1 Ажил нь: “Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем хөгжүүлэлт, сайжруулалтын ажил”

Ажлын талбай нь : “ЦДҮС” ТӨХК-ийн Төв, Улаанбаатар салбар, Төвийн бүсийн салбар, Хангайн бүсийн салбар, Говийн бүсийн салбар, Зүүн өмнөд бүсийн салбар

ГЕН 3.1 Төслийн менежер нь: *Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ч.Нэргүй*

ГЕН 4.1 Зөвшөөрөл авч ажил эхлэсэн өдрөөр тооцогдоно.

Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулсан өдрөөс хойш

Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2019 оны 12 дугаар сарын 31

ГЕН 7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.

ГЕН 9.1 Чанарын баталгаат хугацаа **12 сар** байна. Баталгаат хугацаанд гарсан гэмтэлийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
Барьцаа хөрөнгө гэрээний нийт үнийн дүнгийн **5 хувь** байна.

ГЕН 13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний нийт үнийн **0.05%** байна.

*Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний нийт үнийн **5%** байна.*

ГЕН 17.1 Гүйцэтгэлийн тайланг гэрээ дүгнэж ажил хүлээлцэхэд гаргаж өгнө

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан,

цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]